Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн захирлын 2017 оны А/237 тоот тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Шинжлэх ухаан, технологийн их сургууль 2025 оны санхүүгийн тайлангаа Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 8,198.3 сая төгрөгөөр буюу 4.9 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

*/мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| **Б** | **1** | **2** | **3=2-1** |
| Мөнгөн хөрөнгө | 36,831,627.4 | 42,640,165.3 | 5,808,537.9 |
| Авлага | 2,093,533.8 | 4,310,089.4 | 2,216,555.6 |
| Урьдчилгаа | 1,258,862.3 | 574,737.2 | (684,125.1) |
| Бараа материал | 1,758,708.6 | 947,739.7 | (810,968.9) |
| Үндсэн хөрөнгө | 123,796,792.5 | 125,465,089.7 | 1,668,297.2 |
| **Нийт хөрөнгө** | **165,739,524.6** | **173,937,821.3** | **8,198,296.7** |
| Өр төлбөр | 17,618,568.8 | 20,220,335.2 | 2,601,766.4 |
| Эздийн өмч | 148,120,955.8 | 153,717,486.1 | 5,596,530.3 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **165,739,524.6** | **173,937,821.3** | **8,198,296.7** |

Тайлант онд нөлөө бүхий өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, цэвэр хөрөнгө/ өмчийн данстууд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 42,640.2 сая төгрөг болж, 5,808.5 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд сургалтын төлбөр болон оюутны элсэлтийн тоо нэмэгдсэнтэй холбоотой;
- Авлагын дансны үлдэгдэл 4,310.1 сая төгрөг болж, 2,216.5 сая төгрөгөөр өссөн нь боловсролын зээлийн сангаас санхүүжих 2025 оны буцалтгүй тусламжийн 1,074.0 сая төгрөг, багш нарын хүүхдийн сургалтын төлбөрийн 418.6 сая төгрөг, эрэлттэй мэргэжлээр суралцагчдын 61.7 сая төгрөг, сургалтын зээлийн 636.8 сая төгрөг, Ерөнхийлөгчийн нэрэмжит тэтгэлгийн 509.2 сая төгрөг, Ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлгийн 795.5 сая төгрөгийн санхүүжилт хийгдээгүй нь голлон нөлөөлсөн;
- Бараа материал дансны үлдэгдэл 947.7 сая төгрөг болж, 810.9 сая төгрөгөөр буурсан нь үйл ажиллагаандаа шаардлагатай бараа материалыг 3,542.1 сая төгрөгөөр худалдан авч, 3,886.1 сая төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаандаа зарцуулж, 467.0 сая төгрөгийн бараа материалыг акталж данснаас хассантай холбоотой;
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 125,465.0 сая төгрөг болж, 1,668.3 сая төгрөгөөр өссөн нь дараах шалтгаантай байна. Үүнд:

- Тайлант онд гадаад, дотоодын байгууллага, хувь хүн, төслийн хөрөнгөөр бий болсон 5,359.3 сая төгрөгийн хөрөнгө хүлээн авч, ТӨБЗГ-ын 2025 оны 479 дугаар тогтоолоор Боловсролын ерөнхий газраас 17.0 сая төгрөгийн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэн авч бүртгэж, ТӨБЗГ-ын 2025 оны А1/2039 албан бичгийн дагуу 3 нэрийн газар эзэмших эрхийн үнэлгээг 534.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн бүртгэж, өөрийн хөрөнгөөр 8,546.9 сая төгрөгийн хөрөнгө худалдан авсан;
- ТӨБЗГ-ын 2025 оны 334 болон 508 дугаар тогтоолоор элэгдлээрээ анхны өртгөөрөө нөхсөн 1139 нэрийн 3,810.8 сая төгрөгийн хөрөнгийн үнэ, ашиглах жилийг шинэчлэн тогтоож, 2,889.8 сая төгрөгөөр хөрөнгө бүртгэсэн;
- ТӨБЗГ-ын 2025 оны 342 дугаар тогтоолын дагуу 1,383.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж данс бүртгэлээс хасаж, ТӨБЗГ-ын 2025 оны 344 дүгээр тогтоолын дагуу 44.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг ШУТИС-ийн харьяа Политехник коллеж, ШУТИС-ийн харьяа Хөвсгөл аймаг дахь Политехник коллежид тус тус балансаас балансад шилжүүлж, ТӨБЗГ-ын 2025 оны А1/2039 албан бичгийн дагуу 9 газар эзэмших эрхийн үнэлгээг 1,290.4 сая төгрөгөөр бууруулан бүртгэж, тайлант хугацаанд 14,825.6 сая төгрөгийн элэгдлийн зардал тооцсонтой тус тус холбоотой байна.

- Өр төлбөр дансны үлдэгдэл 20,220.3 мянган төгрөг болж 2,601.8 сая төгрөгөөр нэмэгдсэн нь сургалтын болон оюутны байрны төлбөр болон төсөл гэрээт ажлын урьдчилж орсон орлого 19,391.0 мянган төгрөг, байгууллага, хувь хүмүүст төлөх 797.1 сая төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй холбоотой;
- Цэвэр хөрөнгө/ өмчийн дансны үлдэгдэл 153,717.5 сая төгрөг болж, 5,596.5 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

### 3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Шинжлэх ухаан, технологийн сургуулийн санхүүгийн төлөвлөгөө, техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Тайлант онд нийт орлогыг 98,397.9 сая төгрөгөөр, нийт зардлыг 108,103.9 сая төгрөгөөр төлөвлөж, 9,705.9 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаар баталсан байна. Гүйцэтгэлээр 113,900.1 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 105,945.9 сая төгрөгийн зардал гарган, 5,808.5 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 113,900.1 сая төгрөг болж, төлөвлөснөөс 15,502.7 сая төгрөг буюу 15.8 хувиар давж биелсэн байна. Үүнд сургалтын төлбөрийн орлого 20,778.6 сая төгрөгөөр, тусламжийн орлого 257.3 сая төгрөгөөр тус тус давж биелсэн нь голлон нөлөөлсөн байна. Харин үндсэн бус үйл ажиллагааны орлого 3,903.4 сая төгрөгөөр, төсвийн санхүүжилтийн орлого 1,960.9 сая төгрөгөөр тус тус дутуу биелсэн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 105,945.9 сая төгрөг болж, төлөвлөснөөс 2,157.9 сая төгрөгөөр буюу 2.0 хувиар дутуу зарцуулагдсан байна. Үүнд цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл болон бусад урсгал зардлууд төлөвлөснөөс бага гарсан нь нөлөөлсөн байна.

Мөн өөрийн хөрөнгөөр хийх хөрөнгө оруулалтыг 5,777.5 сая төгрөгөөр төлөвлөснөөс 4,969.0 сая төгрөгийн буюу 86.0 хувийн гүйцэтгэлтэй байна.

## 4. Аудитын тайлан

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн Шинжлэх ухаан, технологийн их сургууль, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Эс Жи Эм Ди-Аудит ХХК-ийн аудитын менежер Б.Оюунцэцэг, ахлах аудитор М.Бямбажаргал, аудитын шинжээч Ч.Ням-Очир, аудитор О.Ганчимэг нар гүйцэтгэж, чанарын хяналтын менежер О.Алтанцэцэг, захирал Д.Насанжаргал нар анхан шатны чанарын хяналтыг, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор С.Бат-Эрдэнэ, аудитын менежер С.Нацагдорж, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Шинжлэх ухаан, технологийн их сургууль 2025 оны санхүүгийн тайлангаа Үндэсний аудитын газарт 2026 оны 02 дугаар сарын 10-ний өдрийн 01/80 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-д заасны дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн 91,514.1 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 915.1 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэн бичгийн цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зардлыг хэмнэх, цалин хөлсийг ажлын гүйцэтгэл, үр дүнтэй нь уялдуулан олгосон, байгууллагаас хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгоогүй, сургалт, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулах арга хэмжээг авч ажилласан байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 4 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамааруулан шалгалаа.

Шинжлэх ухаан, технологийн их сургууль нь 2025 оны мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод мэдээлэх таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын 243 удаагийн 60,220.7 сая төгрөгийн мэдээллийг хуулийн хугацаанд байршуулсан байна.

**Харьяа Дархан-Уул аймаг дахь технологийн сургууль:**

Дархан-Уул аймаг дахь технологийн сургуульд Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах 1,411.2 сая төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, байгууллага, түүний орчин, дотоод хяналт, дотоод аудитын талаар ойлголт авч, мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөгийн дансдын хувьд горим, сорил хэрэгжүүлсэн. Завсрын аудитаар 3 залруулга, 7,650.6 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, 1,403.9 мянган төгрөгийн 9 зөвлөмжийг тус тус өгснөөс жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар хянан үзэхэд хэрэгжүүлж ажилласан байна.

### 5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 503,795.7 сая төгрөгийн зөрчил илэрснээс 1.7 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, 41.6 сая төгрөгийн 1 албан шаардлага, 460.5 сая төгрөгийн 4 зөвлөмж өгснийг 100.0 хувьтай хэрэгжүүлсэн байна.

*Хүснэгт 3. Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

*/мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Төлбөрийн акт | 1 | 1,680.0 | 1 | 1,680.0 | 100.0 |
| Албан шаардлага | 1 | 41,628.4 | 1 | 41,628.4 | 100.0 |
| Зөвлөмж | 4 | 460,487.3 | 4 | 460,487.3 | 100.0 |
| **Нийт дүн** | **6** | **503,795.7** | **6** | **503,795.7** | **100.0** |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

- Өмнөх онуудад Голомт банканд үүссэн тендерийн гүйцэтгэлийн баталгаа болох 16.5 сая төгрөгийн авлагыг барагдуулсан эсэхийг шалгах.
- Төв номын сан, хэвлэлийн газрын санхүүгийн тайлангаар тайлагнасан борлуулалтын орлогын дүнг аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайлантай тулган баталгаажуулах.
- Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн харьяа Нээлттэй боловсролын хүрээлэнд 2025-2026 он дамжин хэрэгжиж буй төслийн бодит гүйцэтгэлийг нарийвчлан анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

## 5. Аудитын илрүүлэлт

Аудитаар нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналтай холбоотой нийт 182.1 сая төгрөгийн 3 алдаа илэрснийг аудитын явцад залруулсан.

Залруулсан алдаа:

- Төлбөр төлөгдөөгүй байхад 137.0 сая төгрөгийг урьдчилж орсон орлогоор бүртгэж тайлагнасан;
- Өмнөх онуудад үүссэн 16.5 сая төгрөгийн авлагыг эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр өмнөх үеийн үр дүн данс руу хаасан;
- Тайлант онд гурван жилийн хугацаатай лицензийг 28.6 сая төгрөгөөр худалдан авч зардлаар бүртгэж тайлагнасан. Тус лицензийг биет бус хөрөнгөөр бүртгэж ашиглалтын хугацаанд хорогдуулан бүртгээгүй зэрэг нь УСНББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга 1.27-т Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой гэсэн заалттай нийцээгүй байсныг залруулсан.

Аудитаар нийт 795.4 сая төгрөгийн 8 зөрчил[1] илэрсэнд, 535.7 сая төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, 259.7 сая төгрөгийн 6 зөвлөмж өгсөн.

Аудитаар илэрсэн 795.4 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 915.1 сая төгрөгөөс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

### 5.1 Албан шаардлага

<u>*1. Илрүүлэлт:*</u> Тус сургуулийн оюутнуудын төлөгдөх эсэх нь тодорхойгүй 326.3 сая төгрөгийн бакалаврын сургалтын төлбөрийн авлага, 127.9 сая төгрөгийн бусад авлагуудыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

<u>*Шийдвэрлэсэн нь:*</u> Авлагын үлдэгдлийг тооцоо нийлээгүй, актаар баталгаажуулаагүй зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

<u>*2. Илрүүлэлт:*</u> Тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй 81.4 сая төгрөгийн спорт заал, хичээлийн өрөөнүүдийн засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа худалдан авах ажиллагааны хууль, журмыг мөрдөөгүй, төсөвт өртгийг хувааж шууд гэрээ байгуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 "Захиалагч шууд худалдан авах,

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

_Шийдвэрлэсэн нь_: Төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулж байгаа зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

**5.2 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**1. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайлагналтай холбоотой асуудал**

_Илрүүлэлт_: Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн төв номын сан, хэвлэлийн газрын санхүүгийн тайлангаар тайлагнасан борлуулалтын орлогын дүн, аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайлангаар тайлагнасан борлуулалтын орлогын дүнгээс 146.3 сая төгрөгөөр зөрүүтэй байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 "Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй" гэж заасантай нийцэхгүй байна.

_Өгсөн зөвлөмж_: Санхүүгийн тайланд тайлагнасан борлуулалтын орлогыг татварын тайланд бүрэн тусгах, борлуулалт хийх бүрд хэрэглэгчид дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримт олгож хэвших

**2. Анхан шатны баримтын бүрдэл дутуу бүртгэсэнтэй холбоотой асуудал**

_Илрүүлэлт_: Хувь хүмүүст ажил гүйцэтгэх гэрээгээр олгосон цалин хөлс түүнтэй адилтгах орлогоос 72.4 сая төгрөгийн Нийгмийн даатгалын шимтгэл суутгаж тайлагнаагүй.

Энэ нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 “Даатгуулагч ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл ногдох орлогын бүрэлдэхүүнд дараах цалин хөлс түүнтэй адилтгах орлогыг хамааруулна: 19.1.2. Иргэний хуулийн 343, 359 зүйлд заасан ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээ болон тэдгээртэй адилтгах гэрээгээ тохирсон цалин хөлс” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

_Өгсөн зөвлөмж_: Ажил гүйцэтгэх болон хөлсөөр ажиллах гэрээгээр олгосон орлогоос ногдох нийгмийн даатгалын шимтгэлийг хууль тогтоомжийн дагуу бүрэн суутган тооцож, тайлагнаж хэвших.

**3. Нэмэгдсэн өртгийн албан татвартай холбоотой асуудал**

_Илрүүлэлт_: Тус сургууль нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн заалтад хамаарах бараа, ажил үйлчилгээ эрхэлж 22.4 сая төгрөгийн орлого олсон ч цахим төлбөрийн баримт олгодоггүй байна.

Энэ нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 "Хуульд өөрөөр заагаагүй бол доор дурдсан бараа, ажил, үйлчилгээнд албан татвар

ногдуулна", 7.1.1 “Монгол Улсын нутаг дэвсгэрт борлуулсан бүх төрлийн бараа, ажил, үйлчилгээ", 7.2 "Доор дурдсан үйл ажиллагааг 7.1-т нэгэн адил хамааруулна: 7.2.7. бараа түрээслүүлэх, бусад хэлбэрээр эзэмшүүлэх, ашиглуулах, 7.2.9. үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө түрээслүүлэх, бусад хэлбэрээр эзэмшүүлэх, ашиглуулах, 7.2.13. "бусдын буруутай үйл ажиллагааны улмаас хүү, торгууль, алданги авах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нэмэгдсэн өртгийн албан татвар ногдох бараа, ажил үйлчилгээний борлуулалт хийсэн тохиолдолд цахим төлбөрийн баримтыг хэрэглэгчид олгож, татварын тайланг хууль тогтоомжийн дагуу үнэн зөв тайлагнаж хэвших.

### 4. Анхан шатны баримтаар баталгаажаагүй зардалтай холбоотой асуудал

*Илрүүлэлт:* Томилолт, хурлын орчуулга, хөтөч болон нислэгийн тийз зэрэгт зарцуулсан 18.0 сая төгрөгийн зардал нь төлбөрийн и-баримтаар баталгаажихгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.14 "Төлбөрийн баримт" гэж тухайн төлбөр тооцоо хийгдсэнийг нотлох он, сар, өдөр, дахин давтагдашгүй төлбөрийн дугаар бүхий нэгдсэн системээр баталгаажсан, албан татвар суутган төлөгч буюу худалдаа эрхлэгчийг таних тэмдэг бүхий нэр, хаяг, татвар төлөгчийн дугаар, худалдаа хийгдсэн бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, төлбөр тооцооны болон татварын дүн зэрэг мэдээллийг агуулсан зориулалтын тоног төхөөрөмжөөс гаргасан цаасан болон цахим баримтыг”, Татварын ерөнхий хуулийн 29 дугаар зүйлийн 29.1.1 "анхан шатны баримт бүрдүүлэх, нягтлан бодох бүртгэлийг тогтоосон журам, нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу төлбөрийн баримтад үндэслэн хөтөлж, татварын тайланг санхүү, аж ахуйн үйл ажиллагааны тайлан тэнцэлд үндэслэн үйлдэх" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Томилолт болон бусад үйл ажиллагааны зардлыг анхан шатны баримт, төлбөрийн и-баримтаар бүрэн баталгаажуулж бүртгэх, баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг санхүүгийн бүртгэлд тусгахгүй байх

### 5. Бүртгэл тайлагнал болон эд хөрөнгийн тооллоготой холбоотой асуудал

*Илрүүлэлт:* Тайлант оны эд хөрөнгийн тооллого явуулах шийдвэрийг бүрэлдэхүүн сургууль бүрээр гаргахдаа ректорын өөр өөр шийдвэрийг үндэслэн гаргасан, тооллогын комисст нэгдсэн сургалт, заавар, чиглэл өгөөгүй, байгууллагын хэмжээгээр тооллогын үр дүнг нэгтгэн тооцоо бодсон актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг

шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.1 "Төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгө, үнэт цаас, мөнгөн хөрөнгийн тооллогыг дотоодын тооллого, улсын тооллого гэж хоёр хуваана", 70.2 "Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана: 1.үндсэн хөрөнгө, дуусаагүй хөрөнгө оруулалт ба барилга угсралтын ажил, их засварын зардлын тооллогыг жилд нэг удаа /12 дугаар сарын 01-нээс 31-ний дотор/, 72 дугаар зүйлийн 72.4 "Тооллогын комисс дараах үүрэгтэй: 1. эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Эд хөрөнгийн тооллогыг байгууллагын хэмжээнд нэгдсэн зохион байгуулалтаар явуулж, тооллогын комисст чиглэл, зааварчилгаа өгч ажиллах.

**Харьяа Дархан-Уул аймаг дахь технологийн сургууль:**

Дархан-Уул аймаг дахь технологийн сургуульд анхан шатны баримтын бүрдэл хангаагүй зардалд хөрөнгө зарцуулахгүй байх 0.6 сая төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| № | Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Төлбөр төлөгдөөгүй байхад 136,950.0 мянган төгрөгийг урьдчилж орсон орлогоор бүртгэж тайлагнасан. | 1 | 136,950.0 | - | - | 1 | 136,950.0 | 1 | 136,950.0 | - | - |
| 2 | Өмнөх онуудад үүссэн 16,544.0 мянган төгрөгийн авлагыг эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр өмнөх үеийн үр дүн данс руу хаасан. | 1 | 16,554.0 | - | - | 1 | 16,554.0 | 1 | 16,554.0 | - | - |
| 3 | Тайлант онд гурван жилийн хугацаатай лицензийг 28,608.0 мянган төгрөгөөр худалдан авч зардлаар бүртгэж тайлагнасан. Тус лицензийг биет бус хөрөнгөөр бүртгэж ашиглалтын хугацаанд хорогдуулан бүртгээгүй байна. | 1 | 28,608.0 | 1 | 28,608.0 | - | - | 1 | 28,608.0 | - | - |
| | **Дүн** | **3** | **182,102.0** | **1** | **28,608.0** | **2** | **153,494.0** | **3** | **182,102.0** | **-** | **-** |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

*/мянган төгрөгөөр/*

| № | Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс: Төлбөрийн акт | | Үүнээс: Албан шаардлага | | Үүнээс: Зөвлөмж | | Үүнээс: Хариуцлага тооцох албан шаардлага | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо |
| 1 | Тус сургуулийн оюутнуудын төлөгдөх эсэх нь тодорхойгүй 326,328.7 мянган төгрөгийн бакалаврын сургалтын төлбөрийн авлага, 127,916.3 мянган төгрөгийн бусад авлагуудыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. | 1 | 454,245.1 | - | - | 1 | 454,245.1 | - | - | - | - |
| 2 | ШУТИС-ийн төв номын сан, хэвлэлийн газрын санхүүгийн тайлангаар тайлагнасан борлуулалтын орлогын дүн, ААНОАТатварын тайлангаар тайлагнасан борлуулалтын орлогын дүнгээс 146,278.1 мянган төгрөгөөр зөрүүтэй байна. | 1 | 146,278.1 | - | - | - | - | 1 | 146,278.1 | - | - |
| 3 | Хувь хүмүүст ажил гүйцэтгэх гэрээгээр олгосон цалин хөлс түүнтэй адилтгах орлогоос 72,409.1 мянган төгрөгийн НДШ суутгаж тайлагнаагүй. | 1 | 72,409.2 | - | - | - | - | 1 | 72,409.2 | - | - |
| 4 | Тус сургууль НӨАТ-ын тухай хуулийн заалтад хамаарах бараа, ажил үйлчилгээ эрхэлж 22,413.6 мянган төгрөгийн орлого олсон ч цахим төлбөрийн баримт олгодоггүй байна. | 1 | 22,413.6 | - | - | - | - | 1 | 22,413.6 | - | - |
| 5 | Томилолт, хурлын орчуулга, хөтөч болон нислэгийн тийз зэрэгт зарцуулсан 18,043.7 мянган | 1 | 18,043.7 | - | - | - | - | 1 | 18,043.7 | - | - |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | төгрөгийн зардал нь төлбөрийн и-баримтаар баталгаажихгүй байна. | | | | | | | | | | |
| 6 | Тайлант оны эд хөрөнгийн тооллого явуулах шийдвэрийг бүрэлдэхүүн сургууль бүрээр гаргахдаа ректорын өөр өөр шийдвэрийг үндэслэн гаргасан, тооллогын комисст нэгдсэн сургалт, заавар, чиглэл өгөөгүй, байгууллагын хэмжээгээр тооллогын үр дүнг нэгтгэн тооцоо бодсон актаар баталгаажуулаагүй байна. | 1 | - | - | - | - | - | 1 | - | - | - |
| 7 | Тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй 81.4 сая төгрөгийн спорт заал, хичээлийн өрөөнүүдийн засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа худалдан авах ажиллагааны хууль, журмыг мөрдөөгүй, төсөвт өртгийг хувааж шууд гэрээ байгуулсан байна. | 1 | 81,438.8 | | | 1 | 81,438.8 | | | | |
| Харьяа Дархан-Уул аймаг дахь технологийн сургууль: | | | | | | | | | | | |
| 8 | Гадаад албан томилолтын зардал олгохдоо анхан шатны баримт бүрдэл дутуу байна. | 1 | 600.0 | - | - | - | - | 1 | 600.0 | - | - |
| | **Дүн** | **8** | **795,428.5** | **-** | **-** | **2** | **535,683.9** | **6** | **259,744.6** | **-** | **-** |

**Харьяа Дархан-Уул аймаг дахь технологийн сургуулийн санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал:**

*/мянган төгрөгөөр/*

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| **Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил** | | | | | | |
| Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 20 мэдээллийг хугацаа хоцроож, 2 мэдээллийг байршуулаагүй байна. | 1 | 1,411,161.2 | 1 | 1,411,161.2 | - | - |
| **Дүн** | **1** | **1,411,161.2** | **1** | **1,411,161.2** | **-** | **-** |

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 03 сарын 16 өдөр | Дугаар 666/А0150458 | Улаанбаатар хот

САГ-2026/89/ИА-СТА-ТБА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус сургуулийн оюутнуудын төлөгдөх эсэх нь тодорхойгүй 326,328,750.00 /Гурван зуун хорин зургаан сая гурван зуун хорин найман мянга долоон зуун тавин/ төгрөгийн бакалаврын сургалтын төлбөрийн авлага, 127,916,383.00 /Нэг зуун хорин долоон сая есөн зуун арван зургаан мянга гурван зуун наян гурван/ төгрөгийн бусад авлагуудыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.7 "авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулахгүй байгаа зөрчлийг арилгах, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн захирал /Т.Намнан/, ерөнхий нягтлан бодогч /Ш.Цэнгэл/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР — Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР — С.НАЦАГДОРЖ

ЭС ЖИ ЭМ ДИ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ — Д.НАСАНЖАРГАЛ

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр. Утас 51-264230*

1526180799

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 03 сарын 16 өдөр    Дугаар 667/А0150458    Улаанбаатар хот

САГ-2026/89/ИА-СТА-ТВА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй 81,438,816.00 /Наян нэгэн сая дөрвөн зуун гучин найман мянга найман зуун арван зургаан/ төгрөгийн спорт заал, хичээлийн өрөөнүүдийн засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа худалдан авах ажиллагааны хууль, журмыг мөрдөөгүй, төсөвт өртгийг хувааж шууд гэрээ байгуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно", 44.1 "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална", 44.3 "Захиалагч санхүүжилтийн эх үүсвэр батлагдсанаас хойш ажлын 10 өдрийн дотор худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг харьяалах дээд шатны төсвийн захирагчид цахим системээр илгээнэ", Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4 "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9 "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулж байгаа зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн захирал /Т.Намнан/, ерөнхий нягтлан бодогч /Ш.Цэнгэл/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР С.НАЦАГДОРЖ

ЭС ЖИ ЭМ ДИ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ Д.НАСАНЖАРГАЛ

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр. Утас 51-264230*

1526180795